

СЭРГЭН МАНДАЛТЫН ҮЕИЙН МОНГОЛЧУУД БА МОНГОЛ ГАРАЛТАЙ ХҮМҮҮС

*О.Нямдаваа**

21 дүгээр зуун бидэнд Монгол эх орноороо бахархах, монгол түүх, соёл, зан заншлаараа бардамнах, түүнийгээ дахин сэргээх, өргөтгөн хөгжүүлэх, сайн цагийг авчирлаа. Энэ зуун Монголын эдийн засаг, улс төр, хөгжил цэцэглэлтийн хувьд Сэргэн мандалтын зуун байгаасаа хэмээн бэлэгшээж гарчигтаа тусгав. Үүнтэй зэрэгцэн нааштай, наашгүйг хослуулсан даяаршил /дэлхийчлэл/ айлчилж байгаа онцлог үед бид амьдарч байгааг хүн бүр мэдэрч байгаад баяртай байна.

Энэхүү торгон боломжийг бид бүхэн мэдрэн мах цусны тасархайтай монголчууд, монголыг судалдаг, талархан дэмжлэг болон монголжуу хүмүүстэйгээ хамтран юу хийх, ямар хувь нэмэр тэдэндээ хүргэн Монгол хэл, соёл, зан заншилаа хөгжүүлж, түүнийгээ авч үлдэхэд хамтран ажиллах талаар чөлөөтэй ярилцах, санал бодлоо хуваалцах таатай үе нээгдлээ.

Өнөөдрийн дэлхий дахины улс төрийн уур амьсгалд гарч буй нааштай өөрчлөлт, дэлхий дахиныг хамарч байгаа даяаршил буюу дэлхийчлэл нь монголчууд биднийг гадаадад гарч нүд тайлах, тэнд амьдарч байгаа монгол ахан дүүстэйгээ уулзах, монголойд буюу монголжуу хүмүүсээ эргэх, тэднийхээ амар мэндийг асуух тэдэнтэйгээ дахин танилцах, Монгол Улсаас гадна амьдардаг бидний мах цусны тасархай болсон хүмүүсийг хооронд нь танилцуулах, бие биетэй нь уулзуулах, бие биендээ зочилох сайхан боломжийг олголоо.

Намайг Нью Делид дэх Элчин сайдын Яаманд 20 орчим жил ажиллах хугацаанд Монгол гаралтай олон хүмүүсээс гомдол сонссоноос энд заримыг дэлгэе гэж бодлоо. Тэднээс “Монголчууд та нар хувиа хичээсэн мах цусныхаа тасархайг бүрэн мартсан хүмүүс. Уг нь биднийгээ эргэж татна, буцааж авна гээд амалсан. Бид та нарыг нүдээ чилтэл зуун зуун жилээр хүлээж харлаа” гэнэ. Хазарачудаас “20 гаруй жил байлдлаа. Энэ хугацаанд Пакистан талибанчуудад, Узбекистаныхан узбекдаа, Тажикстаныхан тажикдаа тусаллаа. Харин Хазара биднийг хүн гэж тоосон, тусалсан, хайрласан хүн байгаагүй. Та нарыг мөн их харсан шүү” гэж намайг 2002 онд Элчин сайдын Яамны барилга байшин, хөрөнгийг эргэн очиход ярьсан тэдний гомдсон үг байв.

1949 онд БНХАУ байгуулагдахад Куньминий монголчууд Монголдоо очих хүсэлт тавихад Жоу Энълай та нар одоогийн нутагтаа олон зуун жил амьдарсан тул дасчихсан байгаа. Бид та нарыг ялган гадуурхахгүй нэгэн адил эрх тэгш амьдрах боломжоор хангана гэснээр асуудал төгсгөл болсон талаар БНХАУ-ын Элчин Яамны нэгэн түшмэл сонирхуулан ярьж байсан юм.

Монголын мах цусны тасархайчуудын талаар зарим нэг хүний хандлагыг хэлье. Монгол Улсын баяр наадмын бэлтгэлийг хангах комиссын хуралд оролцож байсан нэгэн “хүн”-ээс Улсын баярын наадамд Тува,

*О.Нямдаваа - УИХ-ын ГХХАХ-ийн зөвлөх

Буриад, Өвөрмонголын морь, бөхийг оролцуулахгүй гэж зүтгэж байсан юм. Яагаад гэсэн асуултанд манай бүх шагналыг тэд аваад явчихна гэж байсан. Гэхдээ бүх хүмүүс тэр хүн шиг сэтгэл гаргаагүйд би баярласан.

Даяаршлалын авчирч байгаа сайханы зэрэгцээ түүнтэй зэрэгцээд дэлхийчлэл нэгэн адил айлчлан ирж цөөн хэдэн монголчуудын хэл соёл, зан заншил, нүүдлийн ахуй амьдралыг дэлхийчилж эхэллээ. Өөрөөр хэлбэл цөөн монгол үндэстэнүүдийн маань оршин тогтноход агаар үс нэгэн адил лугаа байдаг хэдэн мянган жилийн түүхтэй үндэсний хэл, соёл, зан заншил, эрхэмлэн нандигнаж явдаг болгоноо цаашид авч явахад бас бэрхшээл учирч болох үе нэгэн адил бий болж байна. Монгол Улсын хилийн гадна амьдардаг тэдгээр хүмүүс /монголчууд, монгол үндэстэн, монголжуу хүмүүс/ өөрсдийгөө монголчуудын мах цусны тасархай гэж үзэн Монгол орныг ширтэн, Улаанбаатарт болж байгаа сайхан зүйлийг, дэлхий дахинд монголчуудын гаргаж байгаа ололт амжилтыг сонсоод баярлахын зэрэгцээ бидний талаар хэвлэлд гарсан муу муухай зүйлийг сонсоод гунихран явдагийг би нүдээрээ үзэж, сэтгэлээрээ мэдэрсэн хүний нэг юм. Тэд маань олон сая хүний дотор, олон хүчтэй шашин, соёлын дунд амьдарч монгол хэл соёлоо, зан заншлаа залгуулан өнөөг хүртэл ирээд, цаашид түүнийгээ ялангуяа дэлхийчлэлийн үед авч үлдэж чадах эсэх нь Улаанбаатарт төвтэй монголчуудын бодлогоос хамаарч болох эгзэгтэй үе мөч бий болоод байгааг бид тунгаан эрэгцүүлэн бодох цаг нь ирлээ.

Энэ нь биднийг их хариуцлагатай, их монголжуу, өвөг дээдсийн адил өргөн уужмаар сэтгэж, өнөөдрийн цөөн монголчууддаа туслан хэл соёл, зан заншлаа амьдарч байгаа газар бүрдээ авч үлдэхэд нь дэлхийчлэлийг сөрөн Сэргэн мандалтын Монголын үе хаалт болон зогсохыг түүх биднээс шаардаж эхэллээ.

Үүнээс үүдэн би юу хэлэх гэж байна вэ гэвэл, бидний өмнө их хариуцлага, ачаалал 21 дүгээр зуунд бий болж, Их хаадуудын адилаар уужим тайван дэлхийн хэмжээгээр өргөн сэтгэж, тэднийхээ сургамжийг аль болох өвлөн ажиллаж, Монгол соёл, зан заншил иргэншлээ тэдэндээ үзүүлэх, хэлээ, бичгээ заах, түүхээ үнэн бодит байдлаар дэлхийд тайлбарлан танилцуулахын зэрэгцээ Монголын сэргэн мандалтад тэднийхээ бодол санаа, мэргэжлийн зөвлөлтөө, хувь нэмэр, тусыг нэгэн адил авч ажиллах шаардлага үүсээд байна. Их эзэн Чингис хааныг маань хэрхэн юу гэж ойлгодог дэлхийн улс төрчдийн бодол санааг нэгтгэсэн ном нэгэнтээ Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойгоор гарсан билээ. Тэнд эзэн хааны минь хөдөлмөр, үйл ажиллагааг, монгол баатарлаг эрсийн зориг хатуужил, дэлхийн түүх, шинжлэх ухаан, соёл, ардчилалд оруулсан хувь нэмрийг тэмдэглэсэн байгаа. 21 дүгээр зуунд монголчууд бид гадаадад байгаа монголчууд болон монголжуу хүмүүсийнхээ талаар дэлхийн бодлого явуулж, түүхэндээ мөнхлөгдөх ёстой бус уу.

Тэдэндээ туслах боломж, хүсэл, сонирхол бид бүхэнд байна уу гэсэн асуулт тавихад дийлэнх монголчууд бид бүгдээрээ “байна” гэж хариулна гэсэн бүрэн итгэлтэй байна. Үгүй гэж хариулах хүн бас байж болох. Гэхдээ

тэд 0.1 хувиас хэтрэхгүй. Түүнчлэн тэднийг Монголд ирж суурьшихыг хүсвэл зөвшөөрдөг тусгай систем, хуультай болох асуудлыг үүгээр хөндөж байна. Манай зарим монгол хүнээс “Ирж байгаа хүмүүсийн дотор тагнуул, туршуул хийх гэсэн хүн давхар орж ирээд Монголыг маань Хятадтай, Оростой эсвэл Солонгостой нэгтгэх гээд дайраад ирээдүйд биднийг зовоогоод, тэд зорилгоо биелүүлэхийн тулд том гүрнүүдээс санхүүгийн дэмжлэг авбал яах юм бэ” гэсэн хүн бас байж болох. Гэтэл манай Тагнуулын Ерөнхий газар байдаг. Ихээр мөнгө ирвэл түүнийг шалгадаг Татварын алба, Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн Яамдаа даатгах болно.

Монгол зан заншил, хэл бичгээ заах, түүхээ үнэн байдлаар таниулах их ажлыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нар дэмжиж, УИХ-ын дарга монголчуудыг эргэн ирж суурьших хуулиа гаргаж, ШУА, Монгол судлалын төвүүд болон Монголын төрийн бус байгууллага, эх оронч бизнесменүүдээс уг ажилд тусалж чадах аваас бид үүнийг хийж чадна. Энд хилийн гадаа Монгол Улсыг төлөөлөн алба хашиж байгаа хүн бүрийн хийвэл зохих ажлын нэгэн гэж Та бүгдэдээ ачаалал өгч санал тавьж байгаадаа хүлцэл хүсье. Мөн гадаадад амьдарч байгаа монгол хүн бүрийн үүрэг юм. Тэгэхдээ Таны тэр зүтгэлийг хойч үе тань ойлгон баярлаж, Бурхан тэнгэр нь ивээн тэтгэх болтугай. Энэ талаар манай гарал үүсэл нэгтгэнүүд өөрсдийн санал бодлоо илэрхийлэх байх гэж бодно. Ингэснээрээ бид дэлхийд таран бутарсан олон сая монголчууд, монгол гаралтай хүмүүс, монголжуу хүмүүсийн сэтгэл санааг нээх онгойлгох, бахархуулан баярлуулж тэднээрээ хүндэтгүүлэх юм.

Ингээд юуны өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит цалинж жил бүр БНХАУ-ын дээд монгол, цагаан монгол, Куньминийн монголчууд, Тайванийн монголчууд болон ОХУ-ын Халимаг, Буриад, Тувачуудад, Афганистаны Хазарачууд, Энэтхэгийн Зүүн хойт районы 7 мужийн 30 сая хүмүүсийн төлөөлөгчид болон Хамачал Прадешийн Качори хотод амьдардаг арван мянган жилийн хэлхээ холбоотой гэдэг хүмүүсийн төлөөлөгч нарт өгч байхын зэрэгцээ тэднийг Монголд ирэхэд нь 30 хоног визгүй ирүүлж, байнга амьдрах хүсэлт гаргавал тэднийг хүлээн авах тусгай хууль, зөвшөөрөл гаргаж, монголчуудынхаа тоо толгойг өсгөх, мэдлэгээ зарим хэмжээгээр сэлбэх санал дэвшүүлж байна. Эдгээр монголчуудын ижил төсөөтэй зүйлийн талаар хийсэн зүйл маань нэлээд олон хуудас болох тул Монголч эрдэмтэдийн хурал дээр тавихаар үлдээгээд, Академич Д.Төмөртогоогийн “Эх хэлээ хайрлана гэдэг эх орон, тусгаар тогтнолоо хайрлана” гэсэн үг гэдгээр энэхүү өгүүлэлээ жаргааж байна.